



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 168

Улаанбаатар хот

“Ердийн даатгалын компанийн үйл
ажиллагаанд зайнаас хяналт тавих журам”-ыг
шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг
үндэслэн ТОГТООХ нь:

1.“Ердийн даатгалын компанийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам”-ыг
хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2009
оны “Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх
заавар” батлах тухай 32 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Батлагдсан журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба
/Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2012 оны 08 сарын 20 өдөр дугаар
168 тогтоолын хатгал

**ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНААС
ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

УХА0410 5043239

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос ердийн даатгалын компанийн /цаашид “даатгагч” гэх/ үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих, үнэлгээ, дүгнэлт өгөх /цаашид “хяналт тавих” гэх/-д энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Хяналт тавих зорилго нь даатгагчаас ирүүлсэн тайлан, мэдээ, аудитын байгууллагаар баталгаажуулсан тайлан, тухайн даатгагчтай холбогдох бусад мэдээлэл, тэдгээрт хийсэн тайлбар /цаашид “тайлан, мэдээ” гэх/-т үндэслэн даатгагчийн санхүү, төлбөрийн чадварын байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, үүсч болзошгүй эрсдэлийн түвшинг тогтоох, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах буюу энэ талаарх саналаа Хорооны удирдлагад /цаашид удирдлага гэх/ танилцуулах, холбогдох шийдвэр гаргуулахад оршино.

1.3. Хорооны хянан шалгагч нь /цаашид “хянан шалгагч” гэх/ холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан заавар, журмын дагуу даатгагчид хяналт тавьж ажиллана.

1.4. Хянан шалгагч нь ажил үүргийн хуваарийн дагуу хариуцсан даатгагчтай аливаа ашиг сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус байж, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд баримтлан ажиллана.

1.5. Хянан шалгагч нь зайны хяналтын дүгнэлт өгөх даатгагчийг хариуцаж ажиллахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд Даатгалын газрын даргад бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

Хоёр. Хяналт тавих үйл ажиллагаа

2.1. Хариуцсан хянан шалгагч нь тухайн даатгагчаас ирүүлсэн тайлан, мэдээлэлд үндэслэн түүний үйл ажиллагааны болон цаашид үүсч болзошгүй эрсдэлийн түвшинг тогтоох, санхүү, төлбөрийн чадварт үнэлэлт, дүгнэлт өгнө.

2.2. Хэрэв даатгагчийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд тухайн даатгагчийг хариуцсан хянан шалгагч дараах арга хэмжээ авна.

2.2.1. тухайн даатгагчийн үйл ажиллагаа, санхүү төлбөрийн чадварыг нь сайжруулах чиглэлээр үүрэг даалгавар өгөх;

2.2.2. шаардлагатай гэж үзвэл даатгагчийн үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх саналыг удирдлагад танилцуулах;

2.2.3. газар дээрх шалгалтын ажлын хэсгийг тухайн даатгагчийн тайлан, мэдээллээр хангах, даатгагчаас ирүүлсэн тайлан мэдээний үнэн зөв эсэхийг шалгалтын ажлын хэсгээр шалгуулах, зайлшгүй шалгах шаардлагатай асуудлын жагсаалтыг гаргаж өгөх;

2.1.4. тухайн даатгагчид өөрийн өгсөн болон газар дээрх шалгалтын ажлын хэсгээс өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг шалгах, түүний мөрөөр авах арга хэмжээний талаарх саналаа удирдлагад танилцуулах;

Гурав. Даатгагчийн тайлан, мэдээ, түүнд хяналт тавих

3.1. Хянан шалгагч нь хяналт тавихдаа тухайн даатгагчид холбогдолтой дараах тайлан, мэдээг ашиглана:

3.1.1. холбогдох заавар, журамд заасан болон Хорооноос шаардсан бусад тайлан, мэдээг, тайлбарын хамт;

3.1.2. даатгагчид хийсэн газар дээрх шалгалтын акт материал, танилцуулга;

3.1.3. даатгагчийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, дүгнэлт, түүний тайлбар;

3.1.4. даатгагчийн хяналтын зөвлөл, дотоод хяналтын алба, нэгжийн тайлан, мэдээ;

3.1.5. даатгагч анх байгуулагдахад бүрдүүлж ирүүлсэн баримт материал, түүнд орсон аливаа өөрчлөлтийн талаар тухай бүр ирүүлсэн мэдээлэл;

3.1.6. бусад мэдээлэл (харилцагчдын гомдол, даатгагчийн үйл ажиллагаатай холбоотой хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдсэн мэдээ, мэдээлэл, шүүх, хууль хяналтын байгууллагуудын тухайн даатгагчтай холбогдуулан гаргасан шийдвэр г.м).

3.2. Хянан шалгагч нь хүлээн авсан тайлан, мэдээг дараах байдлаар хянана:

3.2.1. тайлан, мэдээг хууль тогтоомжид заасан хугацаанд нь бүрэн ирүүлсэн эсэх;

3.2.2. эрх бүхий албан тушаалтнууд нь санхүүгийн тайлан, мэдээг үнэн зөв гаргасан болохыг баталгаажуулан гарын үсгээ зурж, тамга, тэмдгээ дарсан эсэх;

3.2.3. санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь Хорооноос мөрдөгдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчимд нийцэж байгаа эсэх;

3.2.4. тайлан, мэдээний үзүүлэлтүүдийг үнэн зөв гаргасан эсэх, тэдгээрийн уялдаа холбоо;

3.2.5. өмнөх тайлант үеийн тайлан, мэдээний үзүүлэлтээс үйл ажиллагаанд нөлөөлөхүйц хэмжээгээр өссөн болон буурсан үзүүлэлтүүдэд тайлбар хийсэн эсэх;

3.2.6. газар дээрх шалгалтын акт материалтай тохирч /зөрчил, дутагдлыг арилгасан эсэх, даатгалын нөөц санг бүрэн байгуулсан эсэх г.м/ байгаа эсэх.

3.3. Тухайн даатгагчийг хариуцсан хянан шалгагч нь энэ зааврын 3.2-т заасан тайлан, мэдээ нь дутуу бол нэмж ирүүлэхийг, шаардлага хангаагүй бол залруулахыг шаардана.

3.4. Даатгагчаас тайлан, мэдээ ирүүлээгүй эсхүл ирүүлсэн тайлан, мэдээ нь хууль тогтоомжид заасан шаардлага хангаагүй бол хянан шалгагч дараах арга хэмжээг шат дараалан авна:

3.4.1. тайлан, мэдээг холбогдох хууль, тогтоомжид заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн тайлан, мэдээ нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй бол шаардлага хангасан тайлан, мэдээг нэн даруй ирүүлэхийг улсын байцаагчийн албан шаардлагаар тухайн даатгагчийн эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх;

3.4.2. энэ журмын 3.4.1-д заасан зөрчлийг давтан гаргасан бол захиргааны хариуцлага ногдуулах;

3.4.3. энэ журмын 3.4.1-д заасан зөрчлийг удаа дараа гаргасан, улсын байцаагчийн албан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох саналыг Хорооны удирдлагад танилцуулах;

3.5. Хянан шалгагч нь тухайн даатгагчаас ирүүлсэн улирал тутмын /шаардлагатай гэж үзвэл сар тутмын/ санхүүгийн тайланд холбогдох хяналтыг хийж, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцон, энэхүү зааврын 1 дүгээр хавсралтын дагуу тайлангийн хариуг боловсруулан, удирдлагад танилцуулж, санхүүгийн тайланг тушаасан өдрөөс хойш 15 өдрийн дотор тухайн даатгагчид хүргүүлнэ.

3.6. Хянан шалгагч нь тухайн даатгагчийн санхүүгийн тайланг хянаж, Даатгалын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан хугацаанаас хойш 3 өдрийн дотор нэгтгэл хариуцсан хянан шалгагчид цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Дөрөв. Даатгагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэл

4.1. Даатгагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэл /цаашид “нэгтгэл” гэх/ хариуцсан хянан шалгагч нь даатгагчийн санхүүгийн тайланг Даатгалын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан хугацаанаас хойш 5 өдрийн дотор нэгтгэлд оруулна.

4.2. Нэгтгэлийн үндсэн үзүүлэлтийн хураангуйд даатгагчийн санхүүгийн үзүүлэлтүүдийг нэгтгэлийн болон бүлгийн дунджаар гаргаж, холбогдох тайлбар, дүгнэлтийг тусгасан танилцуулга бэлтгэнэ.

4.3. Нэгтгэлийн танилцуулгад дараах үзүүлэлтүүдийн талаар он дараалсан судалгаа хийж, график дүрслэлийг хавсаргана:

4.3.1. даатгагчийн нэгтгэлийн ерөнхий үзүүлэлтүүд;

4.3.2. хөрөнгө, өр төлбөр, даатгалын нөөц сан, актив, пассивын бүтэц, холбогдох харьцаанууд;

4.3.3. даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, ашигт ажиллагааны үзүүлэлтүүд;

4.3.5. давхар даатгалын үзүүлэлтүүд;

4.3.6. эрх бүхий байгууллагаас баталсан заавар, журмын дагуу тооцох үзүүлэлтүүд болон нэгтгэлийн байдлыг илтгэх шаардлагатай бусад үзүүлэлтүүд.

4.4. Нэгтгэл хариуцсан хянан шалгагч нэгтгэл, танилцуулгын төслийг Даатгалын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан хугацаанаас хойш 5 өдрийн дотор бэлэн болгож, удирдлагад танилцуулж, баталгаажуулна.

**Тав. Зайнаас тавих хяналтын дүгнэлт бичих,
тавигдах шаардлага, авах арга хэмжээ**

5.1. Хянан шалгагч нь хариуцсан даатгагчийн тухайн улирал, жилийн тайлант хугацааны санхүүгийн үйл ажиллагаа, төлбөрийн чадварт өгөх зайнаас тавих хяналтын дүгнэлт/цаашид “дүгнэлт” гэх/-ийг санхүүгийн тайланг тушаасан өдрөөс хойш 15 хоногийн дотор багтаан боловсруулж, удирдлагад танилцуулна.

5.2. Тухайн улирал, жилийн тайлант хугацааны дүгнэлт нь дараах шаардлагыг хангасан байна:

5.2.1. энэхүү зааврын 2 дугаар хавсралтад заасан бүтцийн дагуу бүрэн гүйцэд боловсруулж, эрсдэлийг үнэн зөв тодорхойлж, цаашид санхүү, төлбөрийн чадварын хүндрэлд орж болзошгүй эсэхийг тогтоосон байх;

5.2.2. хяналтын хүрээнд удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлсэн гэж үзвэл энэ тухай тусгах, боломжгүй гэж үзвэл авах арга хэмжээний тухай саналаа тодорхой дурьдах;

5.2.3. хянан шалгагч нь хариуцсан даатгагчид дүгнэлт өгөхдөө даатгагчийн үзүүлэлтүүдийг авч үзэхээс гадна үйл ажиллагаа явуулах хэлбэр, цар хүрээний хувьд бусад даатгагчийн дундаж, үзүүлэлтүүдтэй харьцуулан авч үзэх;

5.2.4. хянан шалгагч нь хариуцсан даатгагчийн санхүүгийн үзүүлэлтүүдийн өмнөх улирал, тайлант оны эхэн болон өмнөх оны мөн үеэс өөрчлөгдсөн байдал, түүний шалтгааныг илрүүлэн, санхүү, төлбөрийн чадвар болон бусад шаардлагатай гэж үзсэн харьцаануудыг тооцоолон, үнэлгээ, дүгнэлт өгч, холбогдох үзүүлэлтийн динамик судалгааг графикаар гарган хавсаргах;

5.2.5. динамик үзүүлэлтүүдэд төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтүүд болон бусад санхүүгийн үзүүлэлтүүдийг цаг хугацааны дарааллын дагуу тусгах;

5.2.6. эрсдэлийг тооцох, түүний зах зээлийн өөрчлөлтийн мэдрэмжийг тодорхойлох үүднээс төрөл бүрийн шинжилгээний аргууд /Стресс тест, Олон улсын Даатгалын зохицуулалтын байгууллагуудын холбооноос батлан гаргасан стандарт харьцаа болон бусад/- ыг хэрэглэж, дүгнэлт гаргах;

5.2.7. гадаад, дотоодын үнэт цаас эзэмшиж байгаа нөхцөлд зах зээлийн эрсдэлийн шинжилгээ болон зээлийн эрсдэлийн шинжилгээг хийх.

5.3. Хянан шалгагч нь удирдлагад танилцуулсан дүгнэлтийг даатгагчийн хувийн хэрэгт хадгална.

5.4. Хянан шалгагч нь хариуцсан даатгагчийн санхүү, төлбөрийн чадварын байдалд эрсдэл бий болсон нь тодорхой болсон буюу цаашид сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл дүгнэлтэд дараах асуудлуудын талаар дэлгэрэнгүй тусгаж, энэ талаар удирдлагад тухайлан мэдэгдэнэ:

5.4.1. уг зөрчил, дутагдал нь хууль тогтоомж, заавар, журмын холбогдох заалтыг ямар хугацаагаар, хэдэн удаа зөрчсөн;

5.4.2. уг зөрчил, дутагдалтай холбогдуулан тухайн даатгагчийг хариуцсан хянан шалгагчаас авсан арга хэмжээний талаарх жагсаалт;

5.4.3. уг зөрчил, дутагдлыг гаргаснаар даатгагчийн санхүү, төлбөрийн чадварт хэрхэн нөлөөлсөн, цаашид ямар байдлаар нөлөөлөх;

5.4.4. зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний талаар тухайн даатгагчийг хариуцсан хянан шалгагчийн санал.

5.5. Хянан шалгагч нь шаардлагатай гэж үзвэл Даатгалын тухай хуулийн 68.1.1-68.1.5-д заасан албадлагын арга хэмжээ авах санал боловсруулан газар, Хорооны удирдлагад танилцуулна.

5.6. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон даатгагчид зайны хяналт тавих үйл ажиллагааг дуусгавар болгож, хувийн хэргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Хорооны архивт шилжүүлнэ.

Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү журмыг зөрчсөний улмаас холбогдох хууль тогтоомж зөрчигдсөн тохиолдолд буруутай этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээлгэнэ.

“..... ДААТГАЛ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ-Д

Тайлангийн хариу

Танай компани нь 20... оны дугаар сарын-ний өдрийн байдлаар ирүүлбэл зохих санхүүгийн тайлан, мэдээллийг /хугацаанд нь ирүүлсэн, хугацаа хоцроосон бол хэд хоног хоцроосныг бичих/ ирүүлсэн байна.

Даатгалын тухай хуулийн 24, 25 дугаар зүйлүүдэд заасан шаардлага биелэлт дараах байдалтай байна. Үүнд:

1..... ХХК-ийн оны дүгээр улирлын төлбөрийн чадварын үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| 1. Зайлиггүй байх хөрөнгө / $I = \max(1.1, 1.2, 1.3)$ / | | | | |
|--|--|---------------------|------------|-------|
| Үзүүлэлт | | Ирүүлсэн тайлангаар | Тооцсоноор | Зөрүү |
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1.1 Даатгалын хураамжид үндэслэх /Тухай тайлант хугацааны нийт орлогод тооцсон хураамж / (1.1.1 (4)+1.1.2 (4)) | | | | |
| | 1.1.1 Агаарын хөлөг, авто тээврийн хэрэгсэл, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамж | | | |
| | 1.1.2 Бусад хэлбэрийн орлогод тооцсон хураамжийн 20% | | | |
| 1.2 Даатгалын нэхэмжлэлд үндэслэх /Сүүлийн 3 жилийн дунджид үндэслэн/ (1.2.1 (4)+1.2.2 (4)) | | | | |
| | 1.2.1 Агаарын хөлөг, авто тээврийн хэрэгсэл, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн нөхөн төлбөр * 50% | | | |
| | 1.2.2 Бусад хэлбэрийн нөхөн төлбөр * 20% | | | |
| 1.3 Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээ | | | | |
| 2. Нийт хөрөнгө | | | | |
| 3. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө (3.1(4) :3.14(4)) | | | | |
| | 3.1 Бэлэн мөнгө, Банкны харилцах, хадгаламж, хадгаламжийн сертификат, Засгийн газрын бонд, Төв банкны үнэт цаас | | | |
| | 3.2 180 хоногоос доошхи хугацаатай авлага | | | |
| | 3.4 Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг | | | |
| | 3.5 Үл хөдлөх хөрөнгө | | | |
| | 3.6 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас | | | |
| | 3.7 Холбогдох этгээдээс бусад этгээдэд үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан богино хугацаат зээл | | | |
| | 3.8 Орон нутгийн засаг захиргааны бонд | | | |
| | 3.9 Компанийн бонд | | | |
| | 3.10 Эд хогшил, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж | | | |
| | 3.11 Бусад авлага | | | |
| | 3.12 Биет бус хөрөнгө | | | |

| | | | |
|---|--|--|--|
| 3.13 Бараа материал | | | |
| 3.14 Урьдчилж төлсөн зардал | | | |
| 3.15 Бусад хөрөнгө | | | |
| 4. Зөвшөөрөгдөх хөрөнгө / $4=(2)-(3)/$ | | | |
| 5. Өр төлбөр / $5=урт хугацаат өр төлбөр+богино хугацаат өр төлбөр-ОТХ*10\%$ | | | |
| 6. Төлбөрийн чадварын зохистой харьцаа / $6=(4)/(5)\geq 125 /$ | | | |
| 7. Төлбөрийн чадварын хязгаар / $7=(4)-(5)\geq(1) /$ | | | |
| 2. Даатгалын нөөц сан | | | |
| Орлогд тооцоогүй хураамжийн нөөц сан; | | | |
| Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан | | | |
| Нэхэмжилсэн хохирлын нөөц сан | | | |
| Учирч болзошгүй хохирлын нөөц сан | | | |
| 3. Хөрөнгө байршуулах/нийт ба нэгжид ногдох хувнар/ | | | |
| Банкны харилцах, хадгаламж | | | |
| Засгийн газрын бонд | | | |
| Төв банкны үнэт цаас | | | |
| Орон нутгийн засаг захиргааны бонд | | | |
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас | | | |
| Компанийн бонд | | | |
| Үл хөдлөх хөрөнгө | | | |
| Даатгалын тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан холбогдох этгээдээс бусад этгээдэд үл хөдлөх хөрөнгө барьцаалсан богино хугацаат зээл | | | |
| Буруутай этгээдээр төлүүлсэн нөхөн төлбөр болон даатгагчийн авсан даатгуулагчийн сүйрсэн хөрөнгө (Salvage and subrogation recoveries) | | | |
| 180 хоногоос доош хугацаатай авлага | | | |
| Банкны хадгаламжийн сертификат | | | |
| Кассан дахь мөнгө | | | |
| Санхүүгийн болон үйл ажиллагааны түрээс | | | |

Танай ирүүлсэн тайлан тэнцлээс үзэхэд тайлант хугацаанд төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг..... (бүрэн хангасан эсэх, хэрэв хангаагүй бол ямар үзүүлэлтийг, хэдий хугацаагаар хангаагүйг дүгнэж бичих)

(Тайлан мэдээг хугацаа хоцроосон, буруу гаргасан, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт хангаагүй зэрэг зөрчил гаргасан ердийн даатгалын компанийн хувьд дараах байдлаар бичнэ:)

Танай компани нь Даатгалын тухай хуулийн . . дугаар зүйлийн ___ дэх заалт болон Санхүүгийн зохицуулах хорооны оны дүгээр тогтоолоор батлагдсан журам /заавар/-ын __ дэх заалтыг тус тус зөрчсөн тул (ямар арга хэмжээ авснаа бичих, ингэхдээ хуулийн үндэслэлээ тодорхой гаргах)

(Цаашид даатгалын компанийн санхүү, төлбөрийн чадварыг дээшлүүлэх чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатайг зөвлөх. Мөн даатгалын нөөц сангийн тооцоолол, хөрөнгийн байршил болон бусад асуудлаар холбогдох хууль, журам зааврыг зөрчсөн бол зөрчлийг бичих)

ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА.....ХЭЛТСИЙН ДАРГА /...../

**“..... ДААТГАЛ” ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ЗАЙНААС ТАВЬСАН ХЯНАЛТЫН ДҮГНЭЛТ**

/20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс
20... оны ... дугаар сарын ...-ны өдөр/

НЭГ. ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

1. Тусгай зөвшөөрөл авсан огноо, шийдвэрийн дугаар:
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар:
3. Улсын бүртгэлийн дугаар:
4. Регистрийн дугаар:
5. Өмчлөлийн хэлбэр:
6. Албан ёсны хаяг, шуудан, утас, факсын дугаар:
7. Е-мэйл болон вэбсайт:
8. Үүсгэн байгуулагчдын тоо, нэр:
9. Хувь нийлүүлэгчдийн тоо:
10. Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүний тоо:
11. ТУЗ-ийн даргын овог нэр, регистрийн дугаар, утас, е-мэйл:
12. ТУЗ-ийн гишүүдийн овог нэр, регистрийн дугаар, утас, е-мэйл:
13. Эрх бүхий албан тушаалтнуудын овог
нэр, регистрийн дугаар, утас, е-мэйл:
14. Нягтлан бодогчийн овог, нэр, регистрийн дугаар, утас, е-мэйл:
15. Салбар, нэгжийн тоо:
16. Нийт ажиллагсдын тоо:
17. Даатгалын нийт активд эзлэх хувь:
18. Тухайн жилд аудит хийлгэсэн компани:
19. Санхүүгийн тайлангаа хэвлүүлсэн сонингийн нэр, дугаар:
20. Зохицуулалт үйлчилгээний хөлсний хэмжээ, төлсөн он, сар, өдөр:
21. Түдгэлзүүлсэн огноо, үндэслэл:
22. Хүчингүй болгосон огноо, үндэслэл:
23. Газар дээрх шалгалтын талаар /шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хэлбэр,
хийсэн хугацаа, үнэлгээ/:
24. Даатгалын төлөөлөгчийн тоо:

ХОЁР. БАЛАНСЫН БҮТЭЦ /ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД/

2.1 Санхүүгийн тайлангийн харьцуулсан шинжилгээгээр хөрөнгө, эх үүсвэр, орлого зарлагыг бүтцээр нь авч үздэг. Нийт хөрөнгө, эх үүсвэр, даатгалын орлогыг 100% гэж тооцон бусад үзүүлэлтүүдийн хувийн жинг тодорхойлсноор ямар үзүүлэлтийн ач холбогдол өсч, ямар үзүүлэлтийн ач холбогдол буурч байгааг үнэлэх боломжтой.

| БАЛАНСЫН ЗҮЙЛ | Харьцуулсан шинжилгээ | | | |
|--|-----------------------|---|----------|---|
| | Тайлант он | % | Өмнөх он | % |
| А.Хөрөнгө | | | | |
| Эргэлтийн хөрөнгө | | | | |
| Мөнгөн хөрөнгө | | | | |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | | | | |
| Авлага | | | | |
| Бараа материал | | | | |
| 2.Эргэлтийн бус хөрөнгө | | | | |
| Биет хөрөнгө | | | | |
| Биет бус хөрөнгө | | | | |
| Хөрөнгө оруулалт | | | | |
| Нийт хөрөнгийн дүн | | | | |
| Б.Өр төлбөр ба эзэмшигчийн өмч | | | | |
| Давхар даатгалын өглөг | | | | |
| Богино хугацаат өглөг | | | | |
| Нөөц сангийн дүн | | | | |
| Өр төлбөр дүн | | | | |
| Хувьцаа эзэмшигчдийн дүн | | | | |
| Эзэмшигчдийн өмчийн дүн Өр төлбөр ба эзэмшигчийн өмч | | | | |

2.2 Хөрөнгийн байршлын зохистой үзүүлэлтийн талаар

Даатгалын тухай хуулийн 14.2.4-д заасан даатгалын нөөц санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүний хөрөнгө оруулалтад байршуулах тавигдах нөхцөл, шаардлагаар зохицуулж үнэлнэ. Мөн нийт хөрөнгийн байршилд тавигдах шаардлага хангагдаж байгаа эсэх талаар үнэлэлт өгнө.

2.3 Нөөц сан байгуулалт актуар тооцооллын талаар

Нөөц сангийн хүрэлцээтэй байдлыг үнэлэхийн тулд даатгагчийн түүхэн мэдээлэлд суурилна. Нэхэмжлэлийн мэдээллийн бааз, Даатгалын тухай хуулийн 14.2.3-д заасан даатгалын нөөц сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журмаар зохицуулж үнэлнэ. Шаардлагатай тохиолдолд актуарчаар дүгнэлт гаргуулна.

ГУРАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

Даатгалын байгууллагын эцсийн зорилго нь ашгаараа үйл ажиллагаа өргөжүүлэх явдал юм. Ашигт ажиллагаанд хөрөнгө оруулалт, зээлдүүлэгч, хувьцаа эзэмшигчид гол шалгуур болгодог бөгөөд хөрөнгө оруулалт үнийн бодлогын гол хэрэгсэл болдог. Ашигт ажиллагааны шинжилгээг орлогын тайланд үндэслэн гаргана.

А. Орлогын бүтэц бүрэлдэхүүнийг тодорхойлдог.(Даатгалын үйл ажиллагааны орлого, хөрөнгө оруулалт, санхүүгийн үйл ажиллагааны орлого)

Нийт даатгалын орлого 100% гэж тооцон бусад үзүүлэлтүүдийн хувийн жинг тодорхойлно.

| Үзүүлэлт | Тайлант улирал | он, | % | Өмнөх тайлант үе | оны | % |
|-----------------------------------|----------------|-----|---|------------------|-----|---|
| Даатгалын нийт хураамжийн орлого | | | | | | |
| Давхар даатгалын хураамж | | | | | | |
| Буцаасан даатгалын хураамж | | | | | | |
| Даатгалын цэвэр хураамжийн орлого | | | | | | |

Б. Зардлын бүтэц бүрэлдэхүүн (үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал) -ийг тодорхойлно.

Үйл ажиллагааны зардлыг 100% гэж тооцон бусад үзүүлэлтүүдийн хувийн жинг тодорхойлно.

| Үзүүлэлт | Тайлант улирал | он, | % | Өмнөх тайлант үе | оны | % |
|--------------------------------|----------------|-----|---|------------------|-----|---|
| Үйл ажиллагааны зардал | | | | | | |
| Үндсэн болон нэмэгдэл цалин | | | | | | |
| Даатгалын төлөөлөгчийн шимтгэл | | | | | | |
| Бусад зардлууд | | | | | | |

ДӨРӨВ. ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА

4.1 Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн талаар

Даатгалын тухай хуулийн 14.2.2-т заасан “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт түүнд хяналт тавих журам”-ын дагуу тооцно. Төлбөрийн чадварын хязгаар, харьцааг хэрхэн хангасан талаар товч бичнэ.

4.2 Шуурхай шинжилгээ

Компанийн хөрөнгө санхүүгийн байдлыг цөөн үзүүлэлтээр богино хугацаанд тодорхойлж дүгнэлт өгөхөд чиглэдэг.

| | Шинжилгээний зорилго | Үзүүлэлт | Тооцох журам | Өмнөх тайлант үе | оны | Тайлант оны улирал |
|----|----------------------------|--|--|------------------|-----|--------------------|
| 1. | Хөрөнгийн байдлын үнэлгээ | 1.Үндсэн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь 2.Хөрөнгийн элэгдэл 3.Нийт хөрөнгийн өсөлт | 1.Үндсэн хөрөнгө/Нийт хөрөнгө*100% 2.Хур.элэгдэл/ Биет ба биет бус хөрөнгийн анхны өртөг*100% 3. Оны эхний нийт хөрөнгө/оны эцсийн нийт хөрөнгө*100% | | | |
| 2 | Санхүүгийн байдлын үнэлгээ | 1.Өөрийн хөрөнгийн хувийн жин 2.Эргэлтийн харьцаа 3.УХӨТ-ийн нийт эх үүсвэр эзлэх % -ийн жин 4. Нөөц сангийн нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин | 1.Өөрийн хөрөнгө/Нийт эх үүсвэр *100% 2.Эргэлтийн хөрөнгө/БХӨТ 3.УХӨТ/Нийт эх үүсвэр*100% 4. Нөөц сан/Нийт эх үүсвэр | | | |

| | | | | | |
|---|-------------------------------------|---|--|--|--|
| 3 | Ашигт ажиллагааны үнэлгээ | 1.Цэвэр ашгийн өөрчлөлт 2.Нийт ашгийн түвшин 3.Үйл ажиллагааны ашгийн түвшин 4.Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа 5. Даатгагчид үлдэх хураамжийн хувь 6. Даатгалын цэвэр ашгийн хувь 7. Нийт хөрөнгийн ашигт ажиллагаа | 1.ЦА абсолют хэлбэлзэл 2.Нийт ашиг/Орлогод тооцсон хураамж 100% 3.Үйл ажиллагааны ашиг/Даатгалын хураамжийн орлого*100% 4. Цэвэр ашиг/ Өөрийн хөрөнгө 5. Даатгалын цэвэр орлого/ Нийт даатгалын орлого 6. Цэвэр ашиг/Орлогод тооцсон хураамж 7. Цэвэр ашиг/Нийт хөрөнгө | | |
| 4 | Даатгалын үйл ажиллагааны шинжилгээ | Даатгалын үнэлгээ, хураамжийн үнэ тогтоолтын байдлыг тодорхойлоход чиглэгдэнэ. 1.Хохирлын харьцаа 2.Зардлын харьцаа 3.Хосолсон харьцаа 4.Үйл ажиллагааны харьцаа 5. Даатгалын төвлөрлийн үзүүлэлтийг даатгалын эрсдлийн газар зүйн байрлал болон бусад хүчин зүйлээр нь авч үзнэ. 6-8 Өөрийн хөрөнгийн хүрэлцээ | 1. Нийт нэхэмжлэл /орлогод тооцсон хураамж 2. Үйл ажиллагааны зардал/ орлогод тооцсон хураамж 3.Хохирол нөхөлтийн харьцаа+ зардлын харьцаа 4.Хөрөнгө оруулалтын орлогоор тохируулга хийгдсэн холимог харьцаа буюу холимог харьцаан дах орлого тооцсон хураамж дээр хөрөнгө оруулалтын орлогыг нэмнэ. Хэрэв үйл ажиллагааны харьцаа 100 хувиас хэтрэх, хураамжийн орлого, хохирол болон зардлын түвшин тараан байршуулсан хөрөнгөөс хэтэрсэн тохиолдолд хөрөнгө оруулсан хөрөнгийн өгөөжид сөргөөр нөлөөлнө. 6. Дүрмийн сан/хураамжийн орлого 7. Дүрмийн сан/ нөөц сан 8. Дүрмийн сан/нөхөн төлбөр | | |
| 5 | Мэдрэмжийн шинжилгээ | Мэдрэмтгий байдал /Хэрэв шаардлагатай бол тооцож болно./ | 1. Нөхөн төлбөрийн 1 хувийн өөрчлөлтөөс эзэмшигчийн өмчид үзүүлэх нөлөөлөл 2.Инфляцийн түвшний 10 хувийн өөрчлөлтийн даатгалын өр төлбөрт үзүүлэх нөлөөлөл, 3.Хүүгийн түвшний 10 хувийн өөрчлөлтийн хөрөнгөнд үзүүлэх нөлөөллүүд, хөнгөлттэй үед 4. Хүүгийн түвшний 10 хувийн өөрчлөлтийн даатгалын өр төлбөрт үзүүлэх нөлөөллүүдийг тооцно. | | |
| 6 | Өсөлтийн үнэлгээ | 1.ЭХ- ийн эргэц 2.Авлагын эргэц 3.Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа | 1.Даатгалын хураамжийн орлого /Оны эхний ба эцсийн эргэлтийн хөрөнгийн дундаж 2.Даатгалын хураамжийн орлого/Оны эхний ба эцсийн авлагын дундаж 3.Цэвэр ашиг/Өөрийн хөрөнгө /Зөвхөн жилийн эцэст тооцно | | |

ТАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ТҮҮНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД
 -Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд гарсан бүх өөрчлөлтүүдийг бичнэ.

ЗУРГАА. ТУХАЙН ХУГАЦААНД ТУС КОМПАНИД САНХҮҮГИЙН
 ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН ХОЛБОГДОХ ЭРХ БҮХИЙ БУСАД БАЙГУУЛЛАГААС
 АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

| Д/д | Арга хэмжээ авсан байгууллагын нэр | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний | | Зөрчил | Арга хэмжээний товч утга |
|-----|--|------------------------------------|-------|--------|-----------------------------|
| | | хэлбэр | огноо | | |
| | 1. Хорооноос авсан албадлагын арга хэмжээ | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | 2. Хорооноос авсан бусад арга хэмжээ | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | 3. Холбогдох эрх бүхий бусад байгууллагаас авсан арга хэмжээ | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

Жич: Хорооноос авсан албадлагын арга хэмжээнд Хорооны хянан шалгагч, Улсын байцаагчийн тогтоосон акт, мэдэгдэл, шийтгэвэр, хугацаатай үүрэг даалгавар өгөх тухай албан тоот бичиг, Хорооны тогтоол, шийдвэр зэрэг хамаарна. Бусад арга хэмжээнд тус компанид Хорооноос явуулсан бусад албан тоот, тогтоол, шийдвэр хамаарна. Холбогдох эрх бүхий бусад байгууллагаас авсан арга хэмжээний жагсаалтыг тухайн байгууллагуудаас Хороонд ирүүлсэн баримт бичгийг үндэслэж гаргана.

ДОЛОО. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

-Үндэслэл бүхий үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулна.

НАЙМ. ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

- Тухайн даатгагчийг хариуцсан хянан шалгагчийн гаргасан тайлан тэнцэл болон холбогдох тайлан, мэдээллүүд;
- Шаардлагатай бол даатгагчаас ирүүлсэн тайлан мэдээллүүд;
- Дүрмийн сангийн хувь хэмжээ, бүтцийн талаарх мэдээллүүд;
- Даатгагчийн салбар, төлөөлөгчийн газрын талаарх мэдээллүүд

".....даатгал "ХХК-ийн үйл ажиллагаанд зайнаас тавьсан хяналтын дүгнэлтийн 1 дүгээр хавсралт

.....ДААТГАЛ" ХХК-ИЙН ДҮРМИЙН САНГИЙН ХЭМЖЭЭ, БҮТЭЦ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

/.... оны ..-р улирлаас мөн оны ...-р улирлыг хүртэл/
/огноо: он.сар.өдөр/

| Д/д | Хувь нийлүүлэгчдийн талаар | | | Дүрмийн санд оруулсан хөрөнгийн хэмжээ | | Дүрмийн санд хувь хөрөнгө оруулсан огноо | Дүрмийн санд эзлэх хувь | Тайлант хугацаанд дүрмийн сангийн хэмжээнд гарсан өөрчлөлт | Тайлант хугацаанд дүрмийн сангийн бүтцэд гарсан өөрчлөлт |
|-----|----------------------------|------------------|---------|--|---|--|-------------------------|--|--|
| | Нэрс | Дугаар | | Төрийн | Хувийн /Гадаадын хөрөнгө оруулалт орсон эсэх/ | | | | |
| | | Улсын бүртгэлийн | Регистр | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | Нийт | | | | | | | | |

Жич: 1. Тайлант хугацаанд дүрмийн сангийн хэмжээ нэмэгдсэн бол +, хасагдсан бол - гэсэн тэмдэглэлийг дүрмийн сангийн хэмжээнд гарсан өөрчлөлт гэсэн баганад ашиглана.

2. Хэрэв хэт олон хувь нийлүүлэгчтэй бол эзэмших хувьцааных нь нийлбэр нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг эзлэх хувь нийлүүлэгчдийн талаарх мэдээллийг бичнэ.

“..... даатгал ” ХХК-ийн үйл ажиллагаанд зайнаас тавьсан хяналтын дүгнэлтийн 2
дугаар хавсралт

“ . ДААТГАЛ” ХХК-ИЙН САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ТАЛААРХ
МЭДЭЭЛЭЛ

/... оны ..-р улирлаас мөн оны ...-р улирлыг хүртэл/
/огноо: он.сар.өдөр/

| Д/д | Даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газар | | | Тайлант хугацаанд даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газрын бүтэц, байршилд гарсан өөрчлөлт |
|-----|--|----------------------------|---------------------|---|
| | Байршил, албан ёсны хаяг | Үүсгэн байгуулагдсан огноо | Утас, факсын дугаар | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |